



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/369

Мандалговь

Бичил уурхай эрхлэгчдээс
жонш худалдан авах аж ахуйн нэгж
сонгох тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 5.1 дэх заалт, “Ажлын хэсэг томилох тухай” аймгийн Засаг даргын 2018 оны А/369 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2019.04.19-ний өдрийн хуралдааны санал, дүгнэлт, тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын бичил уурхай эрхлэгчдээс жонш худалдан авах аж ахуйн нэгжээр “Мон минералс майнинг энд трейд” ХХК, “Галзоо хан” ХХК-уудыг сонгон шалгаруулж ажиллуулсугай.

Хоёр. Сумын Засаг дарга, худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчдийн хооронд гурвалсан гэрээ байгуулж ажиллахыг Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн ахлагч, аж ахуйн нэгжийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

Гурав. Бичил уурхайн болон худалдан авалтын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар (Ш.Төрбат), Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), холбогдох хууль, хяналт, мэргэжлийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438190615